

БАТЛАВ: "ХАНДИЗЕЛЬ" ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ: *Ж.ТӨГС-ОЮУН*

ATA11354 2015633

ATA11354 2015633

Хандизель ОНӨААТҮГ-ЫН Техникийн Нөхцөл олгох
комиссын 2024 оны 10-р сарын 01-ны өдрийн шийдвэр.

ДУЛААНЫ ШУГАМ СҮЛЖЭЭНД ХОЛБОХ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 13

Хэрэглэгчийн нэр: Сум дундын шүүх ажилчдын байр

Хэрэглэгчийн хаяг: Өмнөговь аймгийн Ханбогд сум Их булаг 3-357

Хэрэглэгчийн байршил: : Өмнөговь аймгийн Ханбогд сум 4-р баг Баян, Баянхөөвөр

1. Холболт авах цэг: 1-р уурын зуухны төв шугамнаас авах

Дулааны эрчим хүчийг хэрэглэх дүрэм, хэрэглэгчийг дулааны шугам сүлжээнд холбох заавар болон бусад хууль тогтоомжуудыг баримталж гүйцэтгэнэ.

Тухайн барилгын дулааны шугам сүлжээний барилга угсралтыг гүйцэтгэхдээ Ханбогд сумын 3-р багт орших 1-р зуухнаас баруун чиглэлийн **X=678602.4057 Y=4784925.9818 Z= -13.9745** координаттай цэгээс салбар шугамын гаргалгаа гаргаж Ф32 ган хоолойгоор отглолгоо авч, холболт хийх таслах хаалт 4ш-ийг өгөх болон буцах шугаманд тус тус тавьж, шугам тус бүрт юулэгч, хий авагчтайгаар угсарч халаалтанд холбогдоно. Сувагжилтыг стандартын дагуу компенсатор, үл хөдлөх тулгуур, дулааны худаг угсарч, шугам хоолойг дулаалгатай, худаг тус бүр шаттай хийж гүйцэтгэнэ.

2. Холболтын цэгийн параметрууд:

- | | |
|----------------------------------|----------------------|
| • Холболтын цэг дээр байх түрэлт | 60 м |
| • Буцах шугамын даралт | 5кгс/см ² |
| • Тооцоот температурын график | 90/70 хэм |

3. Ерөнхий шаардлага:

Хэрэглэгч нь мэргэжлийн эрх бүхий байгууллага, хуулийн этгээдээр зураг төслийг хийлгэнэ. Зураг төсөл зохиогч нь техникийн нөхцөлийн дагуу зураг төслийг боловсруулж, Ханбогд "Хандизель" ОНӨААТҮГ-ЫН ерөнхий инженерээр хянуулан, зургийн нэг хувийг техникийн нөхцөл олгогчид өгнө.

- Зураг төсөлгүй буюу хянуулж баталгаажуулаагүй зураг төслөөр барилга угсралтын ажил гүйцэтгэхийг хориглоно.
- Хэрэглэгчийн дулааны шугам сүлжээг газар доорхи инженерийн шугам сүлжээг дайрч гарах үед уг шугам сүлжээний бүрэн бүтэн байдал алдахаас хамгаалах, зам талбай, мод бүт сөөг эвдэх, тайрах тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг зураг төсөвт тусган хэрэгжүүлнэ. Хэрэглэгч нь шугам сүлжээг угсрах явцад бусад инженерийн сүлжээтэй тааралдаж байгаа бол түүнийг хамгаалах, бүрэн бүтэн байдлыг нь хариуцах үүрэгтэй.

6. Хэрэглэгч нь дулааны шугам зангилаа ба халаалт, салихлуур, халуун ус хангамжийн системийн угсралтын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу "Хандизель" ОНӨААТҮГ-ЫН техникийн ажилтны хяналт, зөвлөмжийн дор гүйцэтгэнэ.
7. Хэрэглэгч нь дулааны шугам зангилаа ба халаалт, салхилуур, халуун ус хангамжийн системийн угсралтын ажлыг хийж дууссаны дараа техникийн нөхцөл олгогчийн төлөөлөгчийг байлцуулан угаалт, шахалт, тохируулга, зүгшрүүлэлтийг хийж холбогдох акт баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:
 - а. Дулааны шугам хоолой болон узелийн паспорт
 - б. Гүйцэтгэлийн зураг
 - с. Ажлын зураг, түүнд зураг төслийн байгууллагатай зөвшөөрөлцөж оруулсан өөрчлөлтүүд
 - д. Дотор гадна шугам сүлжээг угсарсан, туршсан, ил ба далд ажлын актууд
 - е. Гагнуурын холбоосуудыг шалгасан тухай дүгнэлт ба гагнуурчдын үнэмлэх хуулбар
 - ф. Гагнуурын материалыг үйлдвэрлэсэн завод, шугам болон хаалт арматур, хэмжих хэрэгсэл, автомат тохиуурагч тэдгээрийн баталгаат хугацааг илэрхийлсэн акт, үйлдвэрлэгчийн сертификад
 - г. Суурилагдсан арматур, автомат тохиуулагчууд, тооцооны болон хяналтын хэмжүүрүүдийн паспорт
8. Зураг төсөл зохиох, угсралтын ажил гүйцэтгэхэд заавал биелүүлэх шаардлага:
 - а. Шугам сүлжээний ажлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар хийлгэх.\ хувь хүмүүсээр хийлгэсэн шугам сүлжээг хүлээн авахгүй\
 - б. Хэрэгцээний халуун усны гадна дотор шугам сүлжээг дулааны шугамын хамт барьж байгуулах
 - с. Дулааны гадна шугамын зориулалтын сувагжилт гарган БНБД-д нийцүүлэн хийнэ.
 - д. Дотор халаалтын системд тооцооны дагуу дулаан дамжуулалт сайтай зориулалтын халаах хэрэгслийг таслах хоёр хаалтын хамт тавьж жигүүр тус бүрийг таслах хаалт, босоо шугам бүрд тохируулга винтель, хамгийн нам цэгт усыг буулгах юулэгч, өндөр цэгт хий авах боломжтой байхаар агаар гаргагчийг сонгож хийх.
 - е. Дулааны тоолуурыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар тавиулж, баталгаажуулах ба ажил гүйцэтгэсэн акт үйлдэж нэг хувийг техникийн нөхцөл олгогчид хүлээлгэн өгнө.
 - ф. Дулааны зориулалтын узелийн өрөө гаргаж таслах хаалтууд даралт температур тохируулагч хэмжих хэрэгсэлүүдийг дүрмийн дагуу суурьлуулж монтажлаж нэр хаягийг бичсэн байх.
 - г. Угсралт хийх гадна өгөх, буцах шугамыг гулсах болон үл хөдлөх тулгууртай, мөн зэв эсэргүүцэх будгаар 2 үе будаж, шугамын дулаалгыг пенополиуратон материалыар дулаалсан байна.
9. Техникийн нөхцөлийг олгосон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.
10. Техникийн нөхцөлийн шаардлагуудыг хэрэглэгч, зураг төсөв зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд заавал биелүүлэх үүрэгтэй. Техникийн нөхцөлд заагдсны дагуу гүйцэтгээгүй тохиолдолд байнгын ашиглалтанд хүлээн авахаас татгалзна.

11. Олгосон техникийн нөхцлийн шаардлагуудыг захиалагч байгууллага нь зураг төсөв зохиогч болон гүйцэтгэгч байгууллагад албан ёсоор танилцуулж, шаардлагатай бол хувилж өгөх үүрэг хүлээнэ.
12. Олгосон техникийн нөхцөлийг олгогч байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.
13. Инженерийн шугам сүлжээг цааш өргөжин дэвжих бололцоогоор хангаж ДЭХ-ийг дамжуулахад саад учруулахгүй.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

Дулаан хангамжийн инженер:
УХАТ-ЫН инженер:
Тооцооны нягтлан бодогч:

Л.Ганбилэг
Т.Хэрлэн
Д.Нарантуяа



БАТЛАВ: "ХАНДИЗЕЛЬ" ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ: *Оюун-оюут Төгс-оюун*

Хандизель ОНӨААТҮГ-ын Техникийн нөхцөл олгох
комиссын 2024 оны 10-р сарын 01-ны өдрийн
шийдвэр.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 14

- Барилга объектын нэр:** ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМ СУМ ДУНДЫН ШҮҮХ АЖИЛЧДЫН БАЙР
- Барилгын объектын байршил:** ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМ ИХ БУЛАГ 3-357
- Цэвэр усны тооцоо:**
 - а. Хэрэглээ: Тохирсон ачааллаар
 - б. Галын хэрэгцээ: Тохирсон ачааллаар
- Цэвэр усны холболт хийх байршил, өндөржилт шугамын диаметр:**
 - Цэвэр ус: Цэвэр усны салбар шугамын Ф32-тай шугам сүлжээний худаг $X=678602.4057$ $Y=4784925.9818$ $Z= -13.9745$ координаттай цэгээс Ф32x4.9 хоолойгоор гаргалгаа гаргаж холбох.
- Бохир усны тооцоо:**
 - а. Хэрэглээ: Тохирсон ачааллаар
- Бохир усны холболт хийх байршил, өндөржилт шугамын диаметр:**
 - Бохир ус: Бохир усны төв Ф150-тай шугам сүлжээний $X=678610.9304$ $Y=4784925.0593$ $Z=0.0000$ координаттай цэгээс Ф100 хоолойгоор огтолгоо хийж холбох.
- Усан хангамжийн эх үүсвэр:** Гүний худаг, Ус цэвэршүүлэх байгууламж
- Захиалагч ба зураг төслийн байгууллагууд нь техникийн норм, дүрмийг баримтлах ба шугам хоолойн холболтын зураг төслийг "Хандизель" ОНӨААТҮГазартай зөвшилцэх шаардлагатай.
- Шугам сүлжээний ажлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар хийлгэх.
хувь хүмүүсээр хийлгэсэн шугам сүлжээг хүлээн авахгүй\
- Цэвэр, Бохир усны шугамын зураг төсөвд туршилт тохируулгын ажлын зардлыг тусах
- Энэ техникийн нөхцлийн хугацаа нь 1 жил байна. Хугацаа дууссан үед захиалагч байгууллага нь "Хандизель" ОНӨААТҮГазарт хугацааг сунгах буюу дахин шинээр техникийн нөхцөл авах асуудлыг тавина.
- Барилга угсралтын ажлын явцад холболтын зураг төсөвт өөрчлөлт орох шаардлага гарвал "Хандизель" ОНӨААТҮГазарт хянуулж, зохиогчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.
- Ажлын зураг төсвийн нэг хувийг хавсрагдах баримт бичгүүдийн хамт "Хандизель" ОНӨААТҮГазрын архивт өгнө.
- Цэвэр, бохир усны шугамын барилга угсралтын үед газар доорх шугам сүлжээг зөөх, дайрч гарах, зам талбай, хашаа бут сөөг эвдэх тохиолдолд

сэргээх зардал, засмал зам огтолсон тохиолдолд хүчитгэлийн ажлын гарах зардлыг төсөвт тус тус тусгана.

15. Усны тоолур, хэмжүүрийн зангилааг барилга дотор хайрцагт хийнэ.

16. Техникийн нөхцөл олгохтой холбоотой тавигдах шаардлагатай:

1. Ус бага зарцуулах тоног төхөөрөмж тавих
2. Цэвэр усны цагираг шугамнаас огтолгоо хийх шугам унд ахуйн хэрэглээнд нийцсэн байх.
3. Цэвэр усны цагираг шугамнаас огтолгоо хийх шугам 10 ата даралт даах чадамжтай байх.
4. Ажлын зураг хийлгэж “Хандизель” ОНӨААТҮГазартай зөвшилцөх.
5. Барилга дотор галын усны хайрцаг байрлуулах
6. Цэвэр усны шугам дээр Монгол улсын стандарчилал, хэмжил зүйн газарт баталгаажуулсан усны тоолур манометр суурилуулах
7. Тоолуурын заалтыг унших нөхцөлөөр хангах, тоолууртай хайрцаг нь цоож хамгаалалттай байх

17. Гүйцэтгэгч нь цэвэр, бохир усны шугамын холболт хийхдээ “Хандизель” ОНӨААТҮГазрын ашиглалтын инженерээр байнга хяналтын карт хөтлөн ажиллана.

18. Цэвэр, бохир усны шугамын шахалт, туршилтын үед ашиглалтын инженерийг заавал биечлэн байлцуулж ил, далд ажлын акт хөтөлнө.

19. 15,16-р заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд шугам хоолойг ашиглалтанд хүлээн авахгүй цэвэр ус нийлүүлэх боломжгүй.

20. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 11.1.3-т зааснаар хангагч нь хэрэглэгчийн шугамнаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөл олгосон тохиолдолд татгалзахгүй холбуулах.

21. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 11.4-т зааснаар техникийн нөхцөлд тусгагдсан шаардлагыг зөрчихийг хориглоно.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

Дулаан хангамжийн инженер:

Л.Ганбилэг

УХАТ-ын инженер:

Т.Хэрлэн

Тооцооны нягтлан бодогч:

Д.Нарантуяа